



# ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 82

Мандалговь

┌ Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах ┐  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Өндөршил сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 234,000 /хоёр зуун гучин дөрвөн мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй конторын уурын зуухыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Өндөршил сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 7 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 26 дугаар сарын  
30-ний өдрийн 82 тогтоолын хавсралт

Өндөршил сумын Засаг даргын тамгын газрын акталж, данснаас хасах барилгын мэдээлэл

№	Барилга, байгууламжийн нэр	зориулалт	Хэмжих нэгж		Ашиглалт ад орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжих нэгж	Биет хэмжээ					
1	Конторын уурын зуух	Галлагааны	M2	6	1994.08.01	10	234,000	234,000	-
<b>Нийт дүн</b>									
							234,000 /хоёр зуун гучин дөрвөн мянга/ төгрөг	234,000 /хоёр зуун гучин дөрвөн мянга/ төгрөг	-